

**“МАНДАЛГОВЬ-ИМПЕКС” ХК -ИЙ 2022 ОНЫ
ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

Эрхэм хувьцаа эзэмшигчид та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтган мэндчилж байна.

НЭГ. САНХҮҮГИЙН ТАЛААР

2022.12-р сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ Аудит, нягтлан бодох бүртгэлийн зөвлөгөө, хяналтын итгэмжлэгдсэн байгууллага болох “Төгсгүүд консалтинг аудит” ХХК-аар аудитлуулж, аудиторын дүгнэлтийн хамт тус ХК-ий ГЗ-ийн үүрэг гүйцэтгэгч Уранбайгаль ирүүлсэн болно.

1. ХК-ий ӨМЧ:

- 1.1. Энгийн хувьцаа: 71,371 ш энгийн хувьцаа= 92,782,900 төг
- 1.2. Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл: 9,025,600 төг
- 1.3. Эздийн бусад өмч: 13,623,600 төг
- 1.4. Хуримтлагдсан ашиг, алдагдал (84,003,400.00) төг

2. ХӨРӨНГӨ:

- 2.1. Эргэлтийн хөрөнгө:
 - Мөнгө: 634,200 төг
 - Татвар, НШД-ийн авлага: 103,700төг /ААНОАТ/
- 2.2. Эргэлтийн бус хөрөнгө- Үндсэн хөрөнгө: 44,519,500 төг

3. ӨР ТӨЛБӨР: 13,828,700 төг

- 3.1. Татварын өр: 6,208,700төг
- 3.2. Бусад өр төлбөр: 7,620,000 төг

4. 2022 оны ОРЛОГО: 7,283,000

- Ерөнхий удирдлагын зардал: 8,682,300
- Татвар төлөхийн өмнөх ашиг, алдагдал нь: (1,399,300) төг

Аудитлагдсан тайланд мониторинг хийж үзэхэд:

- Хуримтлагдсан ашиг, алдагдал (84,003,400.00) төг байгаа нь үйл ажиллагааг сайжруулж орлого нэмэгдүүлж ашигтай ажиллахыг шаардаж байгаа үзүүлэлт байна.
- Үндсэн хөрөнгөнд ганцхан барилга байгууламж бүртгэлтэй байгаа ба бусад: /машин, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, тавилга, эд хогшил, компьютер, бусад хэрэгсэл, бусад үндсэн хөрөнгө/ ямар ч бүртгэлгүй байна.
- Биет бус хөрөнгөд ямарч бүртгэл байхгүй байна. /газар эзэмших эрх байгаа эсэх нь тодорхойгүй байна/
- Байгууллагад төлөх өглөг 7,620,000 төг гэж байгаа бөгөөд ямар байгууллагад өгөх, хоорондын тооцоо нийлсэн акт байгаа эсэхийг тодруулах
- ААН-ээс төлсөн НДШ-ийн зардал 472,500 төгрөг байгаа нь ажилтан албан хаагчидтай байсан, одоо хүний нөөцийн талаарх мэдээллийг авах

- Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл: 9,025,600 төг байгаа нь ямар хөрөнгийг дахин үнэлүүлсэн талаар мэдээллийг зохих бичиг баримтын хамт авах

2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Улсын бүртгэлийн газраас Мандалговь-импекс ХК-ийн нэр дээр байгаа үл хөдлөх хөрөнгийн талаарх түүхийг өөрийн компанийн албан бичгээр хүсэлт гаргаж лавлагаа, тодорхойлолт авч, Үндсэн хөрөнгийг баримтанд тулгуурлан балансанд бүртгэх
2. Байгууллагад төлөх өглөг 7,620,000 төг гэж байгаа бөгөөд ямар байгууллагад өгөх, хоорондын тооцоо нийлсэн акт байгаа эсэхийг тодруулж бичиг баримтыг авах
3. Одоогийн хүний нөөцийн талаарх мэдээллийг авах
4. Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл: 9,025,600 төг байгаа нь ямар хөрөнгийг дахин үнэлүүлсэн талаар мэдээллийг зохих бичиг баримтын хамт авах
5. 2023 онд санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Компанийн тухай хуульд заасны дагуу нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу тогтоосон хугацаанд гаргаж, санхүүгийн зохицуулах хорооны бүртгэлтэй аудитын байгууллагаар баталгаажуулан харьяа татварын албаар хянуулж, зохих байгууллагуудад хүргүүлэн МУ-ын хууль тогтоомжийг мөрдөн ажиллах
6. “Алтанговь” зочид буудлын засвар тохижилтын асуудлыг шийдвэрлэх
 - Засвар хийх ажлын жагсаалт гаргах
 - Шинээр хийх барилгын ажлын зураг гаргах
 - Дотоод засвар, гүйцэтгэлийн төсөв гаргах
 - Дулааны асуудлаа шийдэх төвийн шугамтай холбох
 - Хөрөнгө оруулалтын асуудлыг шийдэх
 - Хийсэн ажлыг гүйцэтгэлээр бүртгэж, тайлан тооцоог балансанд тусгах
7. Үйл ажиллагааг эхлүүлэхтэй холбоотой менежментийн төлөвлөгөөг гаргах